



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар Б/16

Модот

[Л.Мөнхцэцэгийг ажлаас чөлөөлөх тухай]

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.3, 83 дугаар зүйлийн 83.2, 110 дугаар зүйлийн 110.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Лодойн Мөнхцэцэгийн хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж цаашид сунгагдахгүй болсон тул математик, физикийн багшийн албан тушаалаас 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосугай.

2.Ажил үүргийн дагуу бүрдүүлсэн цаасан болон цахим баримт бичиг, хариуцсан эд хөрөнгө, холбогдох бусад эд зүйлийг хүлээлгэн өгөхийг Л.Мөнхцэцэгт даалгасугай.

3.Л.Мөнхцэцэгтэй тойрох хуудсаар тооцоо хийж, холбогдох эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээн авч, ажил хүлээлцүүлэхийг нярав (Г.Золбоо)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ